



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 31 өдөр

Дугаар А/853

Улаанбаатар хот

Барилга байгууламжуудыг нийслэлийн  
өмчид бүртгэн авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 78 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 72 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баянгол, Налайх, Сонгинохайрхан, Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж ашиглалтад орсон, нийт 8,476,843,946 (найман тэрбум дөрвөн зуун далан зургаан сая найман зуун дөчин гурван мянга есөн зуун дөчин зургаан мянга) төгрөгийн өртөг бүхий, хавсралтад заасан 5 барилга байгууламжийг нийслэлийн өмчид бүртгэн авсугай.

2.Нийслэлийн өмчид шинээр бүртгэж байгаа барилга байгууламжуудыг данс бүртгэлд бүртгэн авч, ашиглалт, хамгаалалтыг хариуцан ажиллахыг хавсралтад заасан эзэмшигч байгууллагуудын удирдлагуудад үүрэг болгосугай.

3.Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (Ч.Сайханбаяр)-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР  
ХОТЫН ЗАХИРАГЧ

Д.СУМЪЯАБАЗАР



Нийслэлийн Засаг даргын 2023 оны  
07 дугаар сарын 31-ны өдрийн  
Н/ЗДЗ дугаар захирамжийн  
хавсралт



### НИЙСЛЭЛИЙН ӨМЧИД БҮРТГЭХ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ

Д/д	Барилга байгууламжийн нэр	Байршил	Ашиглалта д орсон он	Бүртгэх үнэ /төгрөгөөр/	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр
1	317 дугаар цэцэрлэгийн барилга, байгууламж	НД-ийн 3 дугаар хороо	2023	1,050,641,201	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
2	34 дүгээр цэцэрлэгийн барилга байгууламж	БГД-ийн 20 дугаар хороо	2023	2,715,877,961	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
3	294 дүгээр цэцэрлэгийн барилга, байгууламж	СХД-ийн 10 дугаар хороо	2021	1,731,172,882	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
4	Толгойт хөгжлийн төвийн барилга, байгууламж	СХД-ийн 4 дүгээр хороо	2023	1,683,351,902	Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт
5	23 дугаар хорооны Иргэдэд үйлчлэх байр	ХУД-ийн 23 дугаар хороо	2022	1,295,800,000	Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалт
Нийт бүртгэх барилга байгууламжийн дүн				8,476,843,946	